



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны III байр  
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09  
<http://www.ub.inspection.gov.mn>  
E-mail: [ub\\_info@inspection.gov.mn](mailto:ub_info@inspection.gov.mn)

2017.02.20 № 02-01/603

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн удирдлагууд нь хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаагийн улмаас үйлдвэрлэлийн ослын тоо буурахгүй байна.

Иймд доорх хууль тогтоомжийн хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье. Үүнд:

1. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.1.1 дэх заалт:* Машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх;
2. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.1.3 дахь заалт:* Машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх;
3. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.1.2; 9.1.3 дэх заалт:* машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж, техникийн паспортод тэмдэглэх.
4. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.3 дахь заалт:* Цахилгааны тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байх.
5. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.4 дэх заалт:* Цахилгааны тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, газардуулга, газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байх.
6. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.5 дахь заалт:* Дээрх шаардлагыг хангаагүй машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.
7. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.1 дэх заалт:* Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.
8. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.2 дахь заалт:* Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны

1150500862

тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.

9. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.1 дэх заалт:* Үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах,

10. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.2 дахь заалт:* Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;

11. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.4 дэх заалт:* ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;

12. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.6 дахь заалт:* Ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх;

13. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.8 дахь заалт:* Аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх,

14. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.9 дэх заалт:* Хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах;

15. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.14 дэх заалт:* Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж, зориулалтаар нь зарцуулах;

16. *Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт:* Аж ахуйн нэгжийн эрх баригч нь хууль, тогтоомж, нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 36.1, 36.2 дахь заалтуудыг үндэслэн хуулийн хариуцлага хүлээлгэх болохыг мэдэгдье.

ДАРГА



Л.ЭРДЭНЭЧУЛУУН



1. Хан Богд кашемир ХХК
2. "Хос Гол" ХХК
3. "Инел Кашемир" ХХК
4. "Жин Корона" ХХК
5. "Баян Гонгор" ХХК
6. "Хун Жүе" ХХК
7. "Жи Эс Эф" ХХК
8. "Алтай Кашемир" ХХК
9. "Говь" ХК
10. "Түмэн Гонгор" ХХК
11. "ММЖ Капитал" ХХК
12. "Уран Нинж" ХХК
13. "Ви Си" ХХК
14. "Нью Спайс" ХХК
15. "Мөнх Шинэ- Од" ХХК
16. "Буурал Гол" ХХК
17. "Фучиер Холдинг" ХХК
18. "Арилдий" ХХК
19. "Эм Ди Си Пи" ХХК
20. "Үе Импекс" ХХК
21. "Сүүдэртийн Хөндий" ХХК
22. "Мастер Дода" ХХК
23. "Эрдэнэ Чандмана" ХХК
24. "Ялман" ХХК
25. "Батдүмбээ" ХХК
26. "Хатан Төгөл ХХК
27. "Ерөөлт Интернэшнл" ХХК
28. "Мон Ирээдүй" ХХК
29. "Содон Цуурай" ХХК
30. "Медельмен" ХХК
31. "Гурван-Эрдэнэ" ХХК
32. "Их Асар" ХХК
33. "Их Эргэлт" ХХК
34. "Белон" ХХК
35. "Монгол Шевро" ХХК
36. "МЛТЖ" ХХК
37. "Алтайн Харгиа" ХХК